



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2023 – 07 САР | ДУГААР 56

## ГАРЧИГ

2–4	Бодлогын нийтлэл
5–9	Зохицуулалтын мэдээ
10–11	Байр суурь
12–14	Тайлбар ба зөвлөмж
15–16	Компанийн засаглал, комплайнс
17	Тогтвортой санхүүжилт
18–19	Финтек ба регтек
20–23	Судлаачийн индэр
24–25	Факторингийн үйлчилгээ гэж юу вэ?
26–27	Олон улсын зах зээлийн мэдээ
28	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## КАРБОН ЗАХ ЗЭЭЛ

*Мэдээллийг бэлтгэсэн: Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа*


1997 оны Киотогийн протоколоор карбоны зах зээлийг байгуулах санаачилга гарч байсан ба одоогийн байдлаар <https://carboncredits.com/> уг зах зээлийн мэдээллийг нэгтгэж байна.

Карбон зах зээл нь сайн дурын ба олон улсын байгууллага, Засгийн газраас зохион байгуулдаг албан ёсны гэж ангилдаг. Сайн дурын карбон зах зээл нь компаниуд өөрийн хариуцсан нүүрсхүчлийн хийг бууруулах хэмжээнээс ихээр багасгасан нөхцөлд илүү хэмжээгээ зах зээлд борлуулдаг байна. Ингэснээр уг компаниуд нүүрсхүчлийн хийг бууруулах төслүүдийг илүү хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт татдаг.

Компани бүрийн гаргаж буй чанараас хамааран сайн дурын карбон зах зээлийн үнийг тооцоход хэцүү бөгөөд хөндлөнгийн үнэлгээнээр үнэлүүлж, хянуулдаг.

Карбон зах зээл дэх нийтлэг карбон кредитийн төслүүд. Үүнд:

**Сэргээгдэх эрчим хүчний төслүүд** нь карбоны зах зээл үүсэхээс өмнө бий болсон. Олон улс орнууд байгалийн баялаг болох сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй. Тухайлбал Бразил болон Канад улс маш олон усан цахилгаан станц, Дани болон Герман улсууд салхин станцтай нь цахилгаан үүсгүүрийн бага өртөгтэй ба карбон кредитийг үүсгэх үр ашгийг нэмэгдүүлдэг.



Энергийн эх үүсвэрийн үр ашгийг дээшлүүлэх төслүүд нь барилга, дэд бүтцийн энергийн эх үүсвэрийн эрэлтийг

бууруулах байдлаар сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төгс болгодог. Энгийн өдөр тутмын өөрчлөлт нь эрчим хүч бага зарцуулах ЛЭД гэрэл хэрэглэх, харин том зургаараа байшингаа дулаалах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг сайжруулах зэрэг үйл ажиллагаанууд хамаарна.

Үргэлжлэл 17-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ЗОХИЦУУЛАХ, УЯЛДУУЛАХ

Хоёр ба түүнээс дээш талууд гаргах шийдвэр, явуулах үйл ажиллагаагаа нийцүүлэх зорилгоор мэдээлэл солилцох, ажиллагаандаа анхаарах үйл явц.



### COORDINATION

It is the process by which two or more parties take one another into account for the purpose of bringing their decisions and/or activities into harmony.

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ)-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН БОЛОН ДИЙЛЭНХИЙГ БИЕЛҮҮЛСЭН УЛС БОЛЛОО.



Мөнгөугаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхэд олон улсын хэмжээнд хамтын хариу арга хэмжээ авах хүрээнд нэгдсэн стандартыг баримтлах нь нэн чухал юм. Иймд дэлхийн улс орнууд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж болон үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг хангаж ажиллах замаар уг эрсдэлээс урьдчилан сэргийлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцоог бэхжүүлэн ажилладаг. Дээрх зөвлөмж, шалгууруудын биелэлтийг ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагаас тодорхой давтамжтайгаар үнэлж тайлан гаргадаг бөгөөд Монгол улсын хувьд

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (цаашид “АНДМУТБ” гэх)-т харьяалагддаг.

Техник хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс 25 зөвлөмж нь Санхүүгийн зохицуулах хороонд шууд болон шууд бусаар хамааралтай байдаг бөгөөд ФАТФ-аас 2017 онд Монгол Улсад хийсэн Харилцан үнэлгээний тайлангаас хойш ФАТФ-ын зөвлөмж, стандартын хэрэгжилтийг сайжруулах, олон улсын түвшинд үзүүлж буй ахиц, дэвшлийг нэмэгдүүлэх арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны Монгол Улсын явцын тайлангаар ФАТФ-ын техникийн 40 зөвлөмжөөс 39-ийг “бүрэн биелсэн” болон “дийлэнх нь биелсэн” гэж үнэлэгдсэн. Харин ашгийн бус байгууллагыг зүй бусаар

ашиглахтай холбоотой Зөвлөмж 8-ын үнэлгээ “хагас хэрэгжсэн” байсныг ахиулах чиглэлээр төрийн холбогдох байгууллагуудаас шаардлагатай арга хэмжээг авч, 2023 оны явцын тайлангаар дээрх үнэлгээг ахиулах хүсэлтийг хүргүүлээд байсан юм.

АНДМУТБ-ийн 26 дахь удаагийн чуулга уулзалт 2023 оны 7 дугаар сарын 09–14-ний өдрүүдэд Канад Улсын Ванкувер хотноо болсон. Тус чуулга уулзалтад Монгол Улсын 6 дахь удаагийн явцын тайланг хэлэлцүүлж, хамгаалах багийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо ахалж, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Улсын ерөнхий прокурорын газар, Татварын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын төлөөллүүд оролцлоо.

АНДМУТБ-ийн энэхүү чуулга уулзалтаар Монгол Улсын 6 дахь удаагийн явцын тайланг нийт гишүүдийн дунд хэлэлцүүлэн баталж, Монгол Улсын Зөвлөмж 8-ын хэрэгжилтийг “бүрэн биелсэн” болгож 2 шатаар ахиуллаа. Ингэснээр Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ФАТФ-ын техникийн 40 зөвлөмжийг “бүрэн биелсэн” болон “дийлэнх нь биелсэн” гэж үнэлэгдсэн.

Олон улсын хэмжээнд Кайманы арлууд, Латви, Мальта, Макао болон Уругвай гэсэн 5 улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй байдаг бөгөөд Монгол Улсын хувьд Ази, Номхон далайн орнуудаас хоёр дахь орон, дэлхийн улсуудаас зургаа дахь орон боллоо.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороонд шууд хамааралтай Зөвлөмж 15 (шинэ технологи) буюу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбартай холбоотой шинэчлэгдсэн зөвлөмжийн үнэлгээг “дийлэнх нь биелсэн” анхны ФАТФ-ын гишүүн бус орон болсныг АНДМУТБ-ийн удирдлагуудаас онцолж, тусгайлан баяр хүргэсэн. Уг хуралдаанд оролцсон гишүүн болон ажиглагч орнуудын төлөөлөгчид, ФАТФ, АНДМУТБ-ийн нарийн бичгийн дарга нарын зүгээс Монгол Улсын гаргасан амжилтыг онцолж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд томоохон ахиц дэвшил гарч буйг тусгайлан сайшаав.



### ТЕХНИК ХЭРЭГЖИЛТ

ФАТФ-ын Технийн 40 Зөвлөмж	Харилцан үнэлгээ, 2017	2-р Дахин үнэлгээ, 2019	3-р Дахин үнэлгээ, 2020	4-р Дахин үнэлгээ, 2021	5-р Дахин үнэлгээ, 2022	6-р Дахин үнэлгээ, 2023
Биелээгүй	5	0	0	0	0	0
Хагас биелсэн	15	5	3	2	1	0
Дийлэнх нь биелсэн	15	28	29	30	31	31
Бүрэн биелсэн	5	7	8	8	8	9
Нийт	40	40	40	40	40	40

### ДАХИН ҮНЭЛГЭЭ 2023

Шинэчлэгдсэн үнэлгээ /2023.07.14/:

Зөвлөмж 8 – Ашгийн бус байгууллага

Монгол Улсын хувьд ФАТФ-ын 40 Зөвлөмжийг бүрэн хангасан үнэлгээ авсан нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо болоод эрх зүйн орчныг бий болгож, зохицуулалтыг боловсронгуй болгосныг олон улсаас

баталгаажуулж буй явдал төдийгүй эдийн засгийн онцгой ач холбогдолтой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадны томоохон хөрөнгө оруулалт татах зэрэг үйл ажиллагаануудын үүдийг нээж буй хэрэг юм.

### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ



Санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ дэлхийн зах зээлд хүчээ авч уламжлалт санхүүгийн систем хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буйтай холбоотойгоор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх

асуудал олон улсад хурцаар хөндөгдсөн хэвээр байна. Үүнтэй холбоотойгоор ФАТФ-аас гаргаж буй зөвлөмж шаардлагуудын цар хүрээ нэмэгдсэнээс гадна нэлээдгүй олон зөвлөмжүүдэд өөрчлөлт оруулсан нь улс орнуудын хувьд томоохон сорилт болж байна.



Тухайлбал, 2023 оны ФАТФ-ын нэгдсэн хуралдааны үр дүнгээр стратегийн дутагдалтай орон буюу “саарал жагсаалт”-д Камерун, Хорват, Вьетнам, стратегийн ноцтой дутагдалтай орон буюу “хар жагсаалт”-д Мьянмар орон тус тус нэмэгдэж 2023 оны 6 дугаар сарын ФАТФ-ын эцэслэсэн “саарал жагсаалт”-д нийт 26, “хар жагсаалт”-д 3 улс орон багтаж байна. ФАТФ-аас саарал жагсаалтад орсон улс орнуудад өгч буй хугацаатай үүрэг даалгаврын шаардлага нэмэгдэж буй нь Йордан Улс 24, Турк Улс 28, Сенегал Улс 49 хугацаатай үүрэг даалгавар авснаас харагдаж байна. ФАТФ-ын 40 Зөвлөмж, 11 Шууд хэрэгжилтийг үнэлэх шалгуур өсөж, аргачлал боловсронгуй болсонтой холбоотойгоор томоохон улс орнууд саарал жагсаалтад орох үндэслэл болсон.

ФАТФ-аас урьдчилсан байдлаар зарласан дараагийн шатны харилцан үнэлгээний хуваариар Монгол улсад 2028 онд харилцан

үнэлгээ хийхээр тусгасан бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны гол онцлог нь нэг удаагийн шинж чанартай бус, хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэхийг шаарддаг. Иймд дараагийн шатны харилцан үнэлгээнд бэлтгэх, Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны хэмжээнд жил ирэх тусам өргөжин тэлж буй зохицуулалтын салбаруудын онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, салбар тус бүрийн эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, технологид суурилсан хяналт шалгалтын арга техникийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТӨЛӨӨЛӨЛ ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛД ОРОЛЦОО



Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөл / ICURN /-ийн ээлжит хурал энэ сарын 17–19-ний өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо болж зөвлөлийн гишүүн орнуудын зохицуулалтын байгууллагын 70 гаруй төлөөлөгч оролцлоо. Энэхүү хуралд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Хадгаламж, зээлийн хоршооны газрын референт Ц.Доржханд нар оролцож өөрийн орны хадгаламж, зээлийн хоршооны салбарын өнөөгийн нөхцөл байдал, салбарын хуулийн шинэчлэлт, түүний явцын талаар мэдээлэл өгч, санал солилцсон юм.

Энэ удаагийн хурлаар хадгаламж, зээлийн хоршоонд хийх хяналт шалгалт, цаг уурын өөрчлөлтөөс үүсч буй санхүүгийн эрсдэл, кибер аюулгүй байдал, сайн засаглал, хадгаламжийн даатгал зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, санал солилцохын зэрэгцээ үйл ажиллагааныхаа тайланг хэлэлцэв. Улс орнуудын зохицуулагч байгууллагууд хадгаламж, зээлийн хоршоо, түүний гишүүдийг хамгаалах гол арга хэрэгсэл нь эрчимтэй хяналт шалгалт, зохицуулалтаас гадна хадгаламжийн даатгал болохыг хурлаар онцлолоо. Ялангуяа дайн бүхий байдалд буй Украины парламент Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг шинэчлэн баталж, хоршооны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах, хоршоог төлбөрийн системд нэвтрэх боломжийг бүрдүүлэх зэрэг олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт

өөрчлөлтүүдийг хурал эхлэхээс гурван өдрийн өмнө оруулсан нь оролцогчдын анхаарлыг ихэд татсан байна.



Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөл нь бага хэмжээний хадгаламж татдаг олон тооны хоршоодыг хянахад хянан шалгагчдад учирдаг нийтлэг бэрхшээлийг давахад туслах, хянан шалгагч хооронд мэдээлэл солилцох, сайн туршлага судлах боломжоор хангах, сургалтын болон мэдээллийн мэргэжлийн холбоо болох зорилгоор үүссэн. Санхүүгийн зохицуулах хороо 2017 онд зөвлөлийн гишүүн болж, гишүүн орнуудыг хамруулсан арга хэмжээнд тогтмол хамрагдаж байна

### МОНГОЛЫН АНХНЫ РЕЙТИНГТЭЙ БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЭЭ

“Ашид капитал ББСБ” ХХК-ийн “Simple” бондын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлж цан цохих ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Монголын хөрөнгийн биржийн Бизнес хөгжлийн газрын дарга Т.Хаш-Эрдэнэ, “Голомт капитал ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Ган-Эрдэнэ, “Ашид капитал ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Батжаргал болон холбогдох бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал ёслолын арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оролцоог өсгөх, дотоодын аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээр



дамжуулан урт хугацааны санхүүжилт татах хөшүүргийг бий болгох мөн бондын зах зээлийг хөгжүүлэх зорилгоор бодлогын олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний бодит үр дүн гарч “Ашид капитал ББСБ” ХХК-аас санхүүгийн чадавхын зэрэглэлтэй буюу рейтингтэй бондыг олон нийтэд санал болгож байна. Санхүүгийн зохицуулах хороо “Бондын хөтөлбөр”, “Ногоон бонд”, “Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол барьцаагүйгээр бонд гаргах” гэсэн гурван зохицуулалтыг шинээр оруулсан “Өрийн хэрэгслийн журам”-ыг одоогоос хоёр жилийн өмнө буюу 2021 онд баталсан. Өөрөөр хэлбэл бонд гаргагч тодорхой үнийн дүн бүхий бондуудыг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгож, шаардлагатай санхүүжилтийг татах боломж бүхий “Бонд гаргах хөтөлбөр” хэрэгжүүлэх зохицуулалтыг бүрдүүлсэн. Хоёрдугаарт, “Ногоон бонд” гаргах хүрээнд бонд гаргагч санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол барьцаагүйгээр ногоон бонд гаргах боломжтой болсон. Гуравдугаарт, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол барьцаагүйгээр бонд гаргах боломж бүрдсэн. Энэ хүрээнд “Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси” ХХК-д “Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох” тусгай зөвшөөрлийг өнгөрсөн онд олгож дотоодын зэрэглэл тогтоох анхны байгууллагатай болсон. Ингэснээр тус компани зэрэглэл тогтоох үйлчилгээг шинээр нэвтрүүлж анхны үнэлгээгээ “Ашид капитал ББСБ” ХХК-д хийж, “BBB+” буюу дунд зэргийн эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын дундаж зэрэглэлтэй гэж үнэлсэн байна. “Ашид капитал ББСБ” ХХК өмнө нь хөрөнгийн зах зээл дээр нээлттэй бонд гаргаж байсан туршлагатай, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн компани юм. Иймд өнөөдрийн гарч буй бүтээгдэхүүн ч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, олон нийтэд хүлээлт өндөр байх болов уу. Ингээд хөрөнгийн зах зээлд дахин нэг шинэ бүтээгдэхүүн болох анхны рейтингтэй бонд гаргаж буй “Ашид капитал ББСБ” ХХК, Монгол Улсад санхүүгийн зээлжих зэрэглэл тогтоох үйл

ажиллагааг санаачлан бий болгож, тулгын чулууг нь тавьж, хөрөнгийн зах зээлийн түүхэнд нэгэн шинэ хуудсыг нэмж буй Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси” ХХК-ийн хамт олон болон үндсэн андеррайтер “Голомт капитал ҮЦК” ХХК, туслах андеррайтер “Мандал капитал маркетс ҮЦК” ХХК-уудын хамт олонд баяр хүргэж амжилт хүсье” гэсэн юм.

“Ашид капитал ББСБ” ХХК нь 12 сарын хугацаатай, 18 хувийн хүүтэй 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 20 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

## ЕРӨНХИЙ САЙД САНХҮҮГИЙН САЛБАРЫН УДИРДЛАГУУДАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ээлжит өглөөний уулзалтаа “Welcome to Mongolia” уриан дор болж буй “Монголын эдийн засгийн чуулган-2023” хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Монголбанк, арилжааны банкуудын удирдлага болон гадаадын хөрөнгө оруулалтын банкууд, хөрөнгө оруулалтын сангуудын төлөөлөлтэй хийлээ.



Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Монгол Улсын санхүүгийн салбарын нөхцөл байдлын талаар товч мэдээлэл өгөхийн зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд хийсэн онцлох ажлаасаа танилцуулсан юм. Тэрбээр “Гадаадын хөрөнгө оруулагчдад чиглэсэн эрх зүйн орчноо сайжруулж олон улсын жишигт нийцүүлсэн. Төрийн өмчийн реформ, банкны салбарын шинэчлэл, төр хувийн хэвшлийн түншлэл, Хорооноос хэрэгжүүлсэн бодлогын томоохон арга хэмжээний үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3 жил хүрэхгүй хугацаанд 3 их наяд төгрөгөөс 11 их наяд төгрөг

хүртэл өссөний зэрэгцээ зах зээл дээр хувьцаа, бондоос гадна анхны хамтын нээлттэй, хаалттай сангууд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэх зэрэг нийт 70 гаруй шинэ бүтээгдэхүүн гарсан. Мөн олон жил яригдаж байсан ч ажил хэрэг болж чадаагүй байсан Биржийн бус зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж өглөө. Энэ зах зээл үүсээд ердөө жил гаруйхны хугацаа өнгөрч байхад нийт 82 компанийн 2.12 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 108 бондыг бүртгэж, зах зээлээс 1.48 их наяд төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж чадлаа. Гэхдээ хөрөнгийн зах зээлийн арилжааны 97 хувь нь дотоодын хөрөнгө оруулагчид, үлдэх гурван хувь нь гадаадын хөрөнгө оруулагч нар юм. Энэ тоог бид 2026 он гэхэд 60:40 харьцаатай болгох, хөрөнгийн зах зээлийн үнэлгээг 11 их наядаас 30 их наяд төгрөг болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилтод хүрэх, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлэх, тэр дундаа хөрөнгө оруулалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх гарцыг тодорхойлоход чиглэсэн гадаад, дотоодын экспертүүдийн мэдлэг, туршлага, санал зөвлөмжөө хуваалцдаг бодлогын зөвлөл байгуулах боломж бололцоог бий болгохоор эрэлхийлж байна” гэдгийг онцолсон юм.

Уулзалтад Deutsche Bank, UBS, JPMorgan Cazenove, Goldman Sachs, Sumitomo Mitsui, Barclays, Bank of China, Morgan Stanley, US EXIM, Citi, BNP Paribas Exane, HSBC Australia Bank зэрэг олон улсын нөлөө бүхий 48 байгууллагын төлөөлөл оролцов.

### ДААТГАЛЫН БАГЦ ДҮРМИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОО

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын салбарын эрх зүйн шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг сайжруулах чиглэлд тогтмол анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд олон улсын стандарт, чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан даатгагчийн төлбөрийн чадварыг эрсдэлд суурилсан аргачлалаар тодорхойлох, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох зорилгоор даатгагчийн төлбөрийн чадварын тогтмол хувь, хязгаарлалт, дүрэмд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлалд шилжих шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг баталсан.



Даатгагч нар эрсдэлд суурилсан хэлбэрээр өөрийн эрсдэл, төлбөрийн чадвараа тооцоолох, тоо мэдээллийг уг аргачлалд тохируулан ангилж бүртгэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо өөрчлөн сайжруулах хугацаа өгөх, шинэ аргачлал нь даатгагчийн төлбөрийн чадварыг бодитой үнэлж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор уг журам, зааврыг өнгөрсөн оны III, IV улирал болон энэ оны I улиралд туршилтаар хэрэгжүүлсэн. Ингээд эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлт, холбогдох журам, зааврын хэрэгжилтийг дүгнээд “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулаад байна. Мөн давхар даатгалын компани нь даатгалын нөөц сангуудыг ердийн даатгагчтай адил аргачлалаар тооцоолох, даатгалын байгууллагын санхүүгийн нэмэлт тайланд мэдээлэл тусгаж, цахим даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг авах болон бусад нэмэлт зохицуулалтуудыг тусгахаар “Даатгалын багц дүрэм”-ийн 1, 3, 4, 11, 13 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан. Дээрх журамд салбарын оролцогчдын саналыг авахаар нэгдсэн хэлэлцүүлгийг энэ сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Даатгагчийн удирдлага, актуарч, холбогдох албан хаагчид болон зуучлагч компанийн төлөөллүүд оролцсон хэлэлцүүлгээр журам, зааврын төсөлд ирүүлсэн саналууд болон төслийн эцсийн хувилбарыг танилцуулж, оролцогчдын дунд нээлттэй хэлэлцүүлж, санал солилцов.

### ОУВС-ГИЙН КАВКАЗ, ТӨВ АЗИ БА МОНГОЛ УЛСЫН БҮС НУТГИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ТӨВИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун Олон улсын валютын сангийн Кавказ, Төв Ази ба Монгол Улсын бүс

нутгийн чадавхыг сайжруулах төвийн Санхүүгийн хяналт шалгалт, зохицуулалтын чиглэлийн суурин зөвлөх Сэрдар Ганэрийг хүлээн авч уулзан хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



Уулзалтын эхэнд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа, сэндрокс зохицуулалтын орчин, хяналт шалгалтын өнөөгийн нөхцөл байдлын талаарх танилцуулгуудыг хийж, мэдээлэл солилцов. Энэ үеэр дэд дарга Н.Хүдэрчулуун хүрэлцэн ирсэн төлөөлөгчдөд талархаж буйгаа илэрхийлээд “Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын цар хүрээ сүүлийн жилүүдэд хурдацтайгаар өргөжин тэлж буй энэ үед финтек, инсуртек, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг технологид суурилсан эдгээр зохицуулалттай байгууллагуудын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэн дэвшилтэт технологид суурилсан хяналтыг нэвтрүүлэхэд та бүхний туршлага, зөвлөгөө, хамтын ажиллагаа чухал байна” гэдгийг дурдсан юм.

Харин ноён Г.Сэрдар эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохицуулалтын бүх салбарт нэвтрүүлэх чиглэлээр “Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын бодлогын баримт бичиг” баталсныг сайшааж, цаашид сэндроксын зохицуулалтын орчин болон хяналт шалгалтын чиглэлээр туршлага солилцож олон талт хамтын ажиллагаагаа бэхжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

### БНСУ-ЫН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо БНСУ-ын Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, дэд дарга Т.Цэрэнбадрал, Н.Хүдэрчулуун, Даатгалын газрын дарга З.Батболд болон БНСУ-ын талаас Хадгаламжийн даатгалын корпорацийн дарга Ю Жэ Хүн, тус корпорацийн Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ким Ёнг Вон болон холбогдох бусад хүмүүс оролцлоо. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар товч танилцуулахын зэрэгцээ сүүлийн жилүүдэд хийсэн зарим онцлох ажлын талаар мэдээлэл өглөө.



Ялангуяа санхүүгийн зах зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгох замаар санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар танилцуулсан юм. Мөн тэрбээр “Бидний хамтын ажиллагаа санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой гэж харж байна. Цаашилбал санхүүгийн зах зээлийн олон улсын хамтын ажиллагаа өргөжин тэлж, хоёр орны эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах, хил дамнансан хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх, харилцан мэдээлэл солилцох боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна” гэсэн юм.

Хадгаламжийн даатгалын корпораци нь Солонгосын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах чиг үүрэгтэй байгууллага юм.

### САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛЛОО

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын чуулга уулзалт Францын Парис хотноо болж 200 гаруй орны төлөөлөгч, олон улсын байгууллагын ажиглагчид оролцлоо. ФАТФ-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (МУТС, ҮОХЗДС)-тэй тэмцэх тогтолцоо хангалтгүй улсуудын жагсаалт буюу “хар”, “саарал” жагсаалтыг гаргадаг. Мөн энэхүү жагсаалтыг улс орнууд өөрийн мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд цаг тухай бүрд нь хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөдөг.

Энэ удаагийн чуулга уулзалтаар уг жагсаалтыг шинэчилсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын нийт мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн үйл ажиллагаанд үүсэж болох аливаа эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах





үүднээс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо хангалтгүй улсуудын шинэчлэгдсэн жагсаалтыг хүргүүлж байна.

Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд Та харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа энэхүү жагсаалтыг ашиглаж өөрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгож хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

2023 оны 6 дугаар сарын байдлаар

Стратегийн дутагдалтай орон буюу саарал жагсаалтад орсон	Стратегийн ноцтой дутагдалтай орон буюу хар жагсаалтад орсон
<ul style="list-style-type: none"> <li>● Камерун /Шинээр орсон/</li> <li>● Хорват/Шинээр орсон/</li> <li>● Вьетнам /Шинээр орсон/</li> <li>● Мозамбик</li> <li>● Танзани</li> <li>● Албани</li> <li>● Барбадос</li> <li>● Буркина Фасо</li> <li>● Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ)</li> <li>● Кайманы арлууд</li> <li>● Гаити</li> <li>● Гибралтар</li> <li>● Ямайка</li> <li>● Жордан</li> <li>● Мали</li> <li>● Нигери</li> <li>● Панам</li> <li>● Филиппин</li> <li>● Сенегал</li> <li>● Өмнөд Судан</li> <li>● Өмнөд Африк</li> <li>● Сири</li> <li>● Турк</li> <li>● Уганда</li> <li>● Арабын нэгдсэн Эмират улс</li> <li>● Йемен</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Мьянмар</li> <li>● Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ)</li> <li>● Иран</li> </ul>

## БАЙР СУУРЬ

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРТ ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар газрын дарга  
Н.Энхтуяатай ярилцлаа.



**Сайн байна уу, салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаар энэ удаагийн ярилцлагыг эхлүүлье.**

Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага (ФАТФ)-аас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага төрийн хяналт зохицуулалтад ороод багагүй хугацаа өнгөрсөн байна. Санхүүгийн зохицуулах хороо 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 311 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд нь 1,349 агент, 326 брокертойгоор үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн холбогдох журмуудыг батлан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Үл хөдлөх хөрөнгийн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 6 орчим хувийг бүрдүүлдэг улс орны нийгэм, эдийн засагт томоохон ач холбогдол бүхий салбар юм. Монгол улсад барилгын салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжсөнөөр үл хөдлөх хөрөнгийн эрэлт, нийлүүлэлт тогтмол өсөж, зохицуулалтын салбараар үйлчлүүлэх иргэд, олон нийтийн тоо болоод, зохицуулалтын байгууллагын тоо жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байна.

**Сүүлийн жилүүдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал?**

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа нь мэргэжлийн арга зүй дээр тогтдог, үйл ажиллагаандаа мэргэшлийн ёс зүйг баримталж

ажиллах ёстой гэдгээрээ онцлог юм. Ийм учраас салбарын оролцогчдыг чадавхжуулах, тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох, хариуцлагажуулах хүрээнд үл хөдлөх хөрөнгийн брокер, агентыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолоор Үндэсний ажил мэргэжлийн стандартад хамруулан индексжүүлж батлуулсан.

Энэ нь салбарын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч брокер, агентуудын хувьд тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурийг бататгах томоохон алхам болсон. Мөн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд дахь хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн батлаад байна.

**Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар олон улсын хэмжээнд болон манай улсад ямар түвшинд байгаа вэ?**

Санхүүгийн зохицуулах хороо үүсгэн байгуулагдсан үеэсээ эхлэн Монгол Улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, түүнийг хөгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиглэлээр өөр хоорондоо уялдсан үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх салбарын богино, дунд, урт хугацааны хөгжлийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргахдаа судалгаа шинжилгээнд үндэслэж байна.

Тухайлбал, үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын салбарын хяналт зохицуулалт Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэгт шилжин ирсэнтэй холбоотой 2022 онд үл хөдлөх эд хөрөнгийн зуучлал сэдэвтэй томоохон судалгааг хийсэн. Уг судалгаа нь зах зээлийн онцлог, нөлөөлөх хүчин зүйл, бодлого зохицуулалт, зах зээлийн чиг хандлага зэрэг нэлээдгүй асуудлыг хөндөж тусгасан.

Дэлхийн нийт үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ 2022-ны Дэлхийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тайланд 339 тэрбум ам.доллараар үнэлэгдэх бөгөөд нийт үнэлгээний хэмжээгээрээ дэлхийн нийт ДНБ хэмжээнээс 4 дахин их буюу дэлхий даяар нийт олборлосон алтны хэмжээ үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний зөвхөн 4 хувьтай тэнцэж байна. Тэгвэл Дэлхийн үл хөдлөх хөрөнгийн агентлаг, брокерын зах

зээл 2022 онд 1,318.56 тэрбум доллар байсан бол 2023 онд 1,414.35 тэрбум доллар болж, жилийн нийлмэл өсөлтийн хурд (CAGR) 7.3 хувиар өсөх төлөвтэй байна. Өсөлт нь үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын компаниуд үйл ажиллагаандаа өөрчлөлт хийж байгаатай улбаатай.

Үл хөдлөх хөрөнгийн компаниуд үл хөдлөх хөрөнгийн хайлт, барилгын менежмент, дизайн гэх мэт янз бүрийн функцийг гүйцэтгэхийн тулд хиймэл оюун ухааны программуудад хөрөнгө оруулалт хийж байна. Хиймэл оюун ухаан нь үл хөдлөх хөрөнгийн компаниудад үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах хүсэлтэй хүмүүсийг хайж олох, хэрэглэгчийн шаардлагад нийцсэн үл хөдлөх хөрөнгө олох, хэрэглэгчийн зан төлөвт тулгуурлан оффисын талбайг дахин төлөвлөхөд тусалдаг. Drooms-ийн хийсэн судалгаагаар хиймэл оюун ухааны технологи нийлүүлэгчид судалгаанд хамрагдсан үл хөдлөх хөрөнгийн мэргэжилтнүүдийн 54 орчим хувь нь түлхүүр үг хайлтыг сайжруулахын тулд хиймэл оюун ухааныг аль хэдийн ашиглаж байгаа бөгөөд 69 хувь нь хиймэл оюун ухаан нь өндөр хурдтай хайлт хийх замаар компаниудад өрсөлдөх давуу талыг өгдөг гэж үздэг. Жишээлбэл, үл хөдлөх хөрөнгийн REX компани Google зэрэг гуравдагч этгээдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тухайн хүн байшин худалдаж авах эсвэл зарах хүсэлтэй эсэхийг тодорхойлдог. Хамтын ажлын талбараар хангадаг стартап WeWork оффисын талбайн дизайн хийхэд хиймэл оюун ухааныг ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа уламжлалт хэв маягаас дижитал хэлбэрт шилжиж байгаа учраас дэлхийн улс орнуудын зохицуулалт энэ чиглэлд төвлөрөх хандлагатай болж байна.

Түүнчлэн дэлхийн ихэнх улс орнууд үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын чиг үүргийг хууль тогтоомжоор зохицуулсан байдаг бөгөөд тус салбарын тогтвортой байдал, үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтыг гүйцэтгэдэг бие даасан эрх бүхий төрийн байгууллага байдаг. Манай хөрш 2 улсын хувьд авч үзвэл ОХУ-д үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг зохицуулах хууль, журам болон зохицуулалтын байгууллага байдаггүй байсан тогтолцоог өөрчлөхөөр 2020 онд Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдын үйл ажиллагааг сайжруулахаар ОХУ-ын Засгийн газар Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын холбоотой хамтран брокеруудын мэргэшлийн журам гаргасан. Журмын дагуу үл хөдлөх хөрөнгийн зуучлалын брокерын шалгалтад тэнцсэн нөхцөлд зохицуулалтын байгууллагаас зөвшөөрөл, бүртгэл хийлгэх зохицуулалттай. Түүнчлэн ОХУ-ын Засгийн газраас үл хөдлөх хөрөнгийн зуучлалын тухай хуулийг 2023 онд багтаан боловсруулж, батлуулахаар төлөвлөж байна.

Өмнөд хөрш болох БНХАУ-ын хувьд 2016 онд Үл хөдлөх хөрөнгийн тухай хууль баталсан. Тус хуульд үл хөдлөх хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэж буй иргэн нь зохих шатны боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалтад тэнцэж, тусгай зөвшөөрөл авсан байх ёстой гэж заасан. Үл хөдлөх хөрөнгийн тухай хуулийг БНХАУ-ын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан ба үл хөдлөх хөрөнгийн салбартай холбоотой бүх арга хэмжээг зохицуулах заалтыг тусгасан байдаг.

Тэгвэл манай улсын хувьд 2022 онд Засгийн газраас ипотекийн зээлийг 8 хувь байсныг 6 хувь болгон бууруулж, 10 их наядын цогц төлөвлөгөө батлагдаж, энэ хүрээнд барилгын салбарын ажлын байрыг хадгалах, иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрт ипотекийн зээлийг 2 их наядын санхүүжилт олгохоор болсон. Энэхүү 2 их наядын 1 их наядыг 13 мянган зээлдэгчдэд олгоод үлдсэн 1 их наядыг 2022 онд олгосноос 656 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 7,166 зээлдэгчид олгосон бөгөөд үлдсэн 350 тэрбумыг 2023 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн. Гэсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ 15 хувиас 30 хувь хүртэл өссөн үзүүлэлттэй байна. Үнэ ханшийн судалгаанаас харахад орон сууцны үнэ өмнөх жилээс 13.7 хувиар өссөн. Улсын бүртгэлийн газрын тоо баримтаас үзвэл үл хөдлөх хөрөнгийн салбарт сар бүр 3000–3800 орчим үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээгээр шилжсэн зэрэг тоон мэдээнүүд байдаг. Мөн орон сууц шинээр ашиглалтад орох бүтээн байгуулалтыг дагаад зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдийн тоо өсөн нэмэгдэж байна. Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын зах зээлийг сайтар хөгжүүлж чадвал орон сууцны эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх боломжтой юм.

### Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс дурдвал?

Өмнө дурдсанчлан манай улсад үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар дөнгөж хөгжиж эхэлж байна. Иймд бид илүү туршлагатай бусад улсаас зарим зохицуулалт, бодлогын арга хэмжээг нутагшуулан авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Улс орон бүрийн туршлага харилцан адилгүй ч ерөнхийдөө мэргэжилтэнд төвлөрсөн, тэдгээрийн ур чадварт суурилсан зохицуулалтын арга хэлбэрүүдийг хэрэгжүүлэх нь элбэг байна. Өөрөөр хэлбэл, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд оролцож буй мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, салбарт үйл ажиллагаа эрхлэхэд ёс зүйн болон мэдлэг, ур чадварын өндөр шаардлагыг тавьж, түүнийг хангасан этгээдэд үйл ажиллагаа эрхлэх эрх олгох зэрэг зохицуулалтуудыг хэрэгжүүлж байна. Тиймээс бид нэн тэргүүнд салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлд анхаарч, илүү ёс зүйтэй байх, хариуцлагажуулахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн технологийн салбар хурдацтай хөгжиж буй өнөө цагт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа уламжлалт бизнесийн загвараас гадна технологид суурилсан цахим зуучлалын арга барилд шилжих хандлагатай байгаа тул цахим зуучлалыг дэмжиж ажиллах мөн үүнтэй зэрэгцээд хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах тус үйл ажиллагааг хянан зохицуулах шаардлага үүсэж байгаа юм.

Иймд цаашид салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, салбарын оролцогчдыг чадавхжуулж, иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### “УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ (БРОКЕР)–ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ”–ЫН ТАЛААР

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох гурван журмыг дангаар, нэг журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран баталж ЗХХА–ын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Дээрх журмуудын нэг болох “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч (брокер)–ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”–аас уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч буюу брокерийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг танилцуулъя.

#### 1. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавих шаардлага

1.1.Брокерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18–р зүйлийн 18–1т зааснаас гадна энэ журамд заасан дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

- » хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 3 тэрбум 500 сая төгрөгөөс доошгүй байх;
- » хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байх;
- » энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;
- » эрх бүхий албан тушаалтан нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;
- » бирж, тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байх;
- » харилцагчдыг хүлээн авч үйлчлэх ажлын байрны хэсгийг брокероос бусад ажилтны албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байх;

- » арилжаанд оролцогчийн захиалга, биелэлтийг баталгаажуулж, биржид бүртгүүлэх, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, харилцагчид мэдээлэл өгөх бэк оффис /back office/–ын программ хангамжтай байх.

#### 1.2.Брокер үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхэд шаардлагатай дараах бүтэц зохион байгуулалттай байна:

- » үндсэн үйл ажиллагааг явуулах нэгжтэй байх;
- » мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;
- » дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;
- » Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх;
- » эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм журам нь тодорхой, энэ чиглэлээр мэргэжил, туршлагатай хүний нөөцтэй байх.

#### 1.3.Брокерийн эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

- » энэ журамд заасан нэгжийн удирдах албан тушаалтан нь уул уурхай, санхүүгийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан туршлагатай, бусад мэргэжилтэн нь уул уурхай, хууль, худалдаа, санхүү, эдийн засаг, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн байх;
- » тухайн компанид үйлчилгээ үзүүлдэг үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө, хөрөнгийн үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш байх;
- » хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх удирдлага нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх

удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

- » гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах бөгөөд мэргэжилтэн нь ял шийтгэлгүй, компанийн үндсэн ажилтан байх;
- » хуульд өөрөөр заагаагүй бол давхар ажил хавсран эрхэлдэггүй байх;
- » гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь уул уурхай, санхүү, үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;
- » 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд мэргэжилтний 70–аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэдээс бүрдсэн байх.

#### **1.4. Брокерийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх тохиолдолд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:**

- » хувьцааг худалдан авч буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны байх;
- » шинэ хувьцаа эзэмшигч нь энэ журмын Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;
- » хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулсан байх.
- » Нээлттэй хувьцаат компани хэлбэртэй брокерийн тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах, барьцаалах, бусад хэлбэрээр шилжүүлэх тохиолдолд мөн дээрх нөхцөл, шаардлагыг хангана.

#### **1.5. Салбар, төлөөлөгчийн газар байгуулахад дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:**

- » сүүлийн хоёр улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан;
- » салбар, төлөөлөгчийн газар нь байнгын үйл ажиллагаа явуулах хаяг, байршил нь тодорхой ажлын байртай, тухайн салбар, төлөөлөгчийн газарт тогтмол ажиллах эрхлэгч мэргэжилтэнтэй байх;
- » салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж,

программ хангамжтай байх;

- » төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журамтай байх.

#### **1.6. Бусад шаардлага**

- » Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1–д заасан үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь биржээр арилжаалах бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авахад зуучлах брокерийн үйл ажиллагааг энэ журмаар тавигдсан нэмэлт шаардлагыг хангасан нөхцөлд эрхэлж болно.
- » Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжаалахтай холбоотой брокерт тавих нэмэлт шаардлагыг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон үүсмэл санхүүгийн хэрэгслийн журмаар зохицуулна.

#### **2. Брокерийн үйл ажиллагааны зарим зохицуулалтаас**

- » Брокер нь уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр харилцагчийг тогтмол хангаж ажиллана.
- » Брокер нь Хорооноос тогтоосон "Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам"–аар тогтоосон зохистой харьцааг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөнө.
- » Брокер нь өөрийн харилцагчийн арилжааг гүйлгээний төрөл, хэмжээний хувьд зах зээлийг харгалзан үзсэний үндсэн дээр байж болох хамгийн сайн нөхцөлтэйгөөр гүйцэтгэх зарчмыг баримтална.
- » Брокер нь хууль тогтоомжийн дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа, өгсөн зөвлөгөө болон авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг таваас доошгүй жилийн хугацаагаар хадгалах ба бүртгэлийг аюулгүй найдвартай хадгалах үйл ажиллагааг дотоод дүрэм, журмаар тодорхой зохицуулсан байна.
- » Брокерийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх, эрх бүхий албан тушаалтныг томилох, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, оноосон нэр өөрчлөх тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэж, шаардлага хангаж буй эсэхээ тогтоолгосны дараа эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх

ба оршин байгаа газрын хууль ёсны хаяг өөрчлөгдөх, салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хязгаарлах, байршлыг нь өөрчлөх зэрэг тохиолдлуудад Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэнэ.

### 3.Мэдээллийн ил тод байдал

Брокер нь жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор, хагас жил, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол хүргүүлэх ба дараах мэдээллийг харилцагч, олон нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр мэдээлнэ:

- » бүтэц, зохион байгуулалтад орсон өөрчлөлт;
- » үндсэн үйл ажиллагааны танилцуулга, санхүүгийн тайлан, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц хэлцлийн талаар;
- » эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

- » Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд тухай бүр мэдээлэхээр заасан мэдээлэл;
- » арилжааны программ хангамжийг ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж, гарын авлага;
- » олон нийттэй харилцах утас, цахим шуудан, олон нийтийн сүлжээний хаяг, үйл ажиллагаа явуулж буй хаяг байршил;
- » бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;
- » харилцагчийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл;
- » дотоод дүрэм, журамд заасан бусад мэдээлэл.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗҮГЭЭС ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ИТГЭЛИЙГ ХЭРХЭН ТӨЛӨВШҮҮЛЭХ ВЭ? /ҮРГЭЛЖЛЭЛ/

#### Итгэлцлийн төлөвшил


Судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь өөрсдийн компанийн хувьд оролцогч талуудын итгэлцлийг бий болгох талаар идэвхтэй ажилладаг гэж хариулсан хэдий ч олонх компанийн хувьд уг итгэлцлийг бий болгох тал дээр цаашид ажиллах шаардлагатай байгаа нь харагджээ.

Тухайлбал, судалгаагаар дөнгөж 39.0 хувь нь өөрсдийн компанийг итгэлцлийн өндөр түвшинд хүргэж, зорилго, зорилтууд болон

холбогдох гүйцэтгэлийн хэмжүүрүүдээ тодорхойлсон, түүндээ тогтмол хяналт шинжилгээ хийж, мөрөөр нь тууштай арга хэмжээ авдаг, ТУЗ-ийн хурал болон менежерүүдийн түвшинд итгэлийн талаар тогтмол хэлэлцдэг гэж хариулсан бол ихэнх хувь нь итгэлцэл бол бизнесийн хувьд зайлшгүй шаардлага гэж хүлээн зөвшөөрдөг боловч байгууллагын хэмжээнд албан ёсоор мөрдөгддөггүй, итгэлцлийн төлөвшил дунд зэрэг, 16.0 хувь буюу 8 компани тутмын нэг нь итгэлцлийн төлөвшил бага гэсэн байна.

#### Where do you think your organization is on the scale of trust maturity?

- High: Trust objectives and related metrics are well-defined, consistently actioned across all parts of the organization, and regularly discussed at board and executive meetings
- Moderate: Trust is acknowledged as a key business imperative, and sometimes is discussed at board and executive meetings, but it is not yet operationalized across all functional areas
- Low: Trust is not well-defined, measured, or operationalized; discussions are opportunistic and infrequent, not proactive or strategic



Note: N = 177.

Source: The Deloitte Global Boardroom Program Trust Survey.

Эдгээр компаниудад итгэлцлийн талаарх тодорхойлолт байдаггүй, хаяа буюу тохиолдлын шинж чанартайгаар хэлэлцүүлэг өрнүүлдэг боловч итгэлцлийг үйл ажиллагаандаа хараахан хэрэгжүүлж эхлээгүй байна.

Бүс нутгийн хэмжээнд авч үзвэл, судалгаанд Ази-Номхон далай, Америкийн бүс нутгаас оролцогчдын 44.0 хувь нь итгэлцлийн өндөр төлөвшилтэй гэж хариулсан бол Европ, Ойрх Дорнод, Африкийн орнуудаас оролцогчдын 31.0% нь өндөр гэсэн дүн гарчээ.

## Гүйцэтгэх захирал, ТУЗ ба итгэлцлийн хөтөлбөр

Итгэлцлийг төлөвшүүлэх ажлыг хэн удирдан зохион байгуулах үүрэгтэй вэ гэсэн асуултад оролцогчдын дийлэнх буюу 82.0 хувь нь гүйцэтгэх захирал манлайлах үүрэгтэй гэж хариулсан байна. Deloitte Consulting компанийн Ерөнхий зөвлөх, байгууллагын итгэлцлийн удирдагч Майкл Бондар тэрээр, гүйцэтгэх захирлын хамгийн чухал ажил бол удирдлагын багаас өгсөн чиглэлийг тодорхой болгож, үүрэг хариуцлагыг оновчтой хуваарилж, идэвхжүүлэх явдал бөгөөд ингэснээр гүйцэтгэх захирлын итгэлцлийн манлайлал хамгийн үр дүнтэй байдаг гэжээ.

Мөн итгэлцлийг бий болгох төлөвшүүлэх ажиллагаанд компанийн ахлах менежер болон менежментийн багийн тус тусын үүрэг оролцоог хуваарилан, хэрэгжүүлэх нь чухалд тооцогддог. Компаниуд байгууллагын итгэлцлийн удирдлагыг томилохгүй байж болох ч итгэлцлийг бий болгох, төлөвшүүлэх ажиллагаа нь авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд тулгуурлаж байгааг хянах, түүнийг удирдах шаардлагатай байдаг гэж үзэж байна.

ТУЗ-ийн гишүүд итгэлцлийн хөтөлбөрийг удирдаж, хэрэгжилтийг үр дүнтэй хангахад дэмжлэг болох үүднээс гүйцэтгэх захирал нь ажлын гүйцэтгэлээ ТУЗ-д тогтмол тайлагнаж байх ёстой байдаг. Санал асуулгад оролцогчдын дийлэнх нь (95.0 хувь) оролцогч талуудын итгэлцлийг бий болгох, төлөвшүүлэхэд ТУЗ гол үүрэг гүйцэтгэх ёстой гэж үзсэн бол дөрөвний гурваас илүү нь (77.0 хувь) ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын багтай хариуцлагаа хуваалцах үүрэгтэй, 18.0 хувь нь ТУЗ-ийн үндсэн үүрэг гэж үзсэн.

Рио Тинто компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Саймон Хенри: "Манай ТУЗ компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой олон арга хэмжээ авч хэрэгжүүлдэг, ялангуяа ажиллагсдын албан ёсны судалгаа, шууд ба шууд бус оролцоо, түүний дотор соёл, зан үйлийн асуудлаарх дотоод аудитын тайлантай холбоотой олон үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

### 95% of respondents say the board either owns or co-owns the trust agenda

Is the board responsible for managing stakeholder trust?



Note: N = 177.

Source: The Deloitte Global Boardroom Program Trust Survey.

Итгэлцлийн цогц зураглалыг бий болгох зорилгоор авч үздэг олон үзүүлэлт байдаг, эдгээрийн зарим нь шог ярианд үндэслэсэн бол зарим нь тогтсон бүтэцтэй, хэмжигдэхүйц санал хүсэлт дээр

суурилдаг. Хамгийн гол нь ажиллагсдын санал хүсэлтийг тогтмол авч, хариу үйлдэл үзүүлж хэвших нь туйлын чухал юм" гэжээ.

Үргэлжлэл бий...


Эх сурвалж: [www.deloitte.com](http://www.deloitte.com)



# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## КАРБОН ЗАХ ЗЭЭЛ

### Карбон болон метаны хийг хадгалах:



**Ойжуулалт** нь карбоныг агаар мандлаас шингээдэг. Ойжуулалтын процесс бол ой модыг нөхөн сэргээж хамгаалах, шинэ ой мод байгуулах, хөрсний менежмент хийх юм.



### ХАРИУЦЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН ХАНДЛАГА

Олон нийтийн уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотой хариуцлагатай хөрөнгө оруулалт хийх эрэлт нэмэгдсээр байна. Хариуцлагатай хөрөнгө оруулалт гэдэг нь зөвхөн үр өгөөж өгөхөөс гадна байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй байх хүчин зүйлсийг үнэлэн хөрөнгө оруулалт хийх юм.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлууд хөндөгдөж, Ковид-19-ын

цар тахал олон нийтийг уг асуудалд улам ч илүү ач холбогдол өгөх болгосон. ААН-үүд байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй нөхцөлд л санхүүжилт татаж чадах болжээ. АНУ-д мэргэжлийн хөрөнгө оруулагчид нийт хөрөнгө оруулалтынхаа 8.4 их наяд төгрөг буюу 13 хувийг тогтвортой хөрөнгө оруулалтад оруулсан байдаг.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ИНСУРТЕК БА ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт инсуртек болон түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Финтекийн салбарын нэг хэлбэр болох Инсуртек нь даатгал болон технологи-ийг хослуулсан даатгалын салбарыг сайжруулан өөрчлөхөд технологи, дижитал инноваци, дата аналитик ашиглахыг хэлдэг. Энэ нь даатгалын компаниудын үр ашиг, үйлчлүүлэгчийн туршлага, ерөнхий үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн янз бүрийн технологийн дэвшил, инновацийг хамардаг.

Даатгалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, үйл явцыг оновчтой болгох, эрсдэлийн үнэлгээ, андеррайтерийн чадавхыг сайжруулахын тулд Insurtech компаниуд хиймэл оюун ухаан (AI), блокчэйн, юмсын интернэт (IoT), том өгөгдлийн аналитик зэрэг шинээр гарч ирж буй технологиудыг ашигладаг. Эдгээр технологи нь даатгагчдад асар их хэмжээний өгөгдөл цуглуулж, дүн шинжилгээ хийх, гар аргаар хийх даалгавруудыг автоматжуулах, өөрт тохирсон бодлого санал болгох, нэхэмжлэлийн удирдлагын үйл явцыг сайжруулах боломжийг олгодог.

Insurtech нь даатгалын салбарт хэд хэдэн мэдэгдэхүйц өөрчлөлтийг авчирсан бөгөөд үүнд:

- ◆ Хэрэглэгчийн туршлагыг сайжруулсан: Insurtech нь хэрэглэгчдэдээ даатгалын бодлогыг хялбархан судлах, худалдан авах, удирдах боломжийг олгодог хэрэглэгчдэд ээлтэй онлайн платформ болон гар утасны программуудыг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлсэн. Энэ нь мөн хувь хүний эрсдэлийн профайл дээр тулгуурлан хувийн бодлогын саналуудыг идэвхжүүлж, нэхэмжлэл гаргах, харилцахад тохиромжтой дижитал сувгуудыг хангасан.
- ◆ Үр ашиг, зардлын хэмнэлтийг нэмэгдүүлсэн: Даатгалын төрөл бүрийн үйл явцыг автоматжуулж, дижиталчилснаар үйл ажиллагаа жигдэрч, бичиг цаасны ажил багасаж, үр ашиг дээшилсэн. Insurtech шийдлүүд нь автоматжуулсан андеррайтинг, нэхэмжлэлийн боловсруулалт, бодлогын удирдлага, залилан мэхлэлтийг илрүүлэх боломжийг

бүрдүүлсэн нь даатгагч болон үйлчлүүлэгчдийн зардлыг хэмнэх боломжийг олгодог.

- ◆ Өгөгдөлд тулгуурласан ойлголт, эрсдэлийн үнэлгээ: Insurtech нь их хэмжээний өгөгдөлд дүн шинжилгээ хийж, утга учиртай ойлголтыг гаргахын тулд дэвшилтэт аналитик болон AI алгоритмуудыг ашигладаг. Энэ нь даатгагчид эрсдэлийн үнэн зөв үнэлгээ хийх, үнийн бодлогыг илүү үр дүнтэй хийх, залилан мэхлэх үйлдлийг илрүүлэх боломжийг олгодог.
- ◆ Даатгалын шинэ бүтээгдэхүүн, бизнесийн загвар: Insurtech нь даатгалын шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжсэн. Жишээлбэл, үе тэнгийн даатгалын платформ нь хувь хүмүүст эрсдэлээ нэгтгэж, нийгэмд өөрийгөө даатгах боломжийг олгодог. Хүсэлтийн дагуу даатгалын загварууд нь үйлчлүүлэгчдэд тодорхой хугацаа эсвэл үйл явдлын даатгалд хамрагдах боломжийг олгодог. Нэмж дурдахад, IoT-ийг дэмждэг төхөөрөмжүүд, тухайлбал, тээврийн хэрэгсэл эсвэл өмсдөг төхөөрөмж дэх телематикууд нь хэрэглээнд суурилсан даатгал, бодит цагийн эрсдэлийг хянах боломжийг олгодог.

Инсуртек нь дижитал өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, хөгжиж буй салбарт өрсөлдөх чадвартай хэвээр үлдэхийг эрмэлзэж буй хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид болон уламжлалт даатгалын компаниудын анхаарлыг ихээхэн татаж байна. Энэ нь инновацийг хөгжүүлж, даатгалын янз бүрийн талыг өөрчлөн шинэчилж, салбарын хувьд илүү үр ашигтай, үйлчлүүлэгч төвтэй, технологийн дэвшилтэт ирээдүйрүү замчилж байгаа юм.

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тойм 2023 оны нэгдүгээр сард нийтлэгдсэн бөгөөд үүнд инсуртекийн талаар холбогдох тоон үзүүлэлтүүдийг дараах байдлаар тусгажээ.

Инсуртек салбарт хийсэн дэлхийн хөрөнгө оруулалт 2022 онд сүүлийн долоон жилийн доод түвшинд буюу 7.1 тэрбум ам.долларт


хүрч буурсан нь сүүлийн жилүүдэд олон нийтэд нээлттэй болсон хэд хэдэн даатгалын технологийн компаниудад тулгарч буй IPO-гийн дараах гүйцэтгэлийн сорилттой холбоотойгоор зарим хөрөнгө оруулагчдын татан авалтыг илэрхийлж байж магадгүй юм. Хэдийгээр удаашралтай байгаа ч эерэг тэмдэглэлүүд байсан: 2022 оны сүүлийн хагаст бүх гурван гол бүс (Жишээлбэл: Америк, Европ, Ойрхи дорнод, Африк, Ази–Номхон далайн) томоохон хэлэлцээрүүдийг татсан, тэр дундаа АНУ–д төвтэй Metromile компанийг Lemonade компани 500 сая долларын худалдан авалт хийж дуусгасан (Анх 2021 сүүлийн хагаст–д зарласан), Германд төвтэй Wefox 400 сая долларын венчур хөрөнгө оруулалт, АНУ–ын Pie Insurance 315 сая долларын венчур хөрөнгө оруулалт, Сингапурт төвтэй Bolttech 300 сая долларын венчур хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2022–ын сүүлийн хагасын онцлох үйл явдлууд

Инсуртекийн хөрөнгө оруулагчид ажиглаж байна: 2022 он бол инсуртекийн хөрөнгө оруулалтын хувьд харьцангуй нам гүм жил байсан тул олон инсуртекийн хөрөнгө оруулагчид макро эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал болон үнэлгээ буурсан, олон нийтийн зах зээл дэх инсуртекийн гүйцэтгэлийн улмаас тодорхойгүй байдлыг хүлээхээр түр завсарласан. Ялангуяа үнэлгээ тогтворжих тусам хөрөнгө оруулагчид дахин нүүдэл хийж эхлэх хандлагатай байна.

Инсуртекийн хөрөнгө оруулагчид ашигт ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж байна: 2022 оны туршид инсуртекийн хөрөнгө оруулагчид ашигт ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж, компаниудын өсөлтөд бага анхаарлаа хандуулсан, ашиг олох арга замд илүү анхаарсан. Энэ нь зарим гарааны бизнес эрхлэгчид өөрсдийн компанийн үнэ цэнэ хаана байгааг технологийн болон даатгалын үүднээс дахин үнэлэхэд хүргэж байна.

Зураг. Инсуртекийн хөрөнгө оруулалтын хэлэлцээр



Эх сурвалж: KPMG

# СУДЛААЧИЙН ИНДЭР

## ББСБ-ЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА /ХУРААНГУЙЛСАН ХЭСЭГ/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

### ОРШИЛ

Монгол Улсад банк бус санхүүгийн байгууллагын цахим мөнгөн гуйвуулгын зохицуулалттай холбоотой судалгааны ажил хийгдээгүй гэж үзэхээр байна. Иймд цахим мөнгөн гуйвуулгын талаар ойлголт өгөх, өөрийн болон бусад орны зохицуулалтын арга хэрэгсэл, туршлага зэргийг тодорхойлж судаллаа.

Мөнгөн гуйвуулга нь банкаар дамжиж хийгддэг гүйлгээ байсан бол өнөөдөр банк бус санхүүгийн байгууллага энэхүү үйлчилгээг харилцагчдадаа нэвтрүүлээд даруй 10 гаран жилийн нүүр үзэж байна.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 514 банк бус санхүүгийн байгууллага/ББСБ/ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 40 ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Мөнгөн гуйвуулга нь санхүүгийн хүртээмжийг хөнгөвчлөх, ингэснээр хуримтлал, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх, ажлын

### Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт П.Байгалмаа

байр бий болгоход эергээр нөлөөлдөг. Ийм ч учраас улс орнууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ихээхэн дэмжихийн сацуу үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах үр дүнтэй зохицуулалтыг бий болгоход анхаардаг.

Энэхүү судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Нэгдүгээр бүлэгт дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээл, Хоёрдугаар бүлэгт цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой олон улсын байгууллагаас боловсруулсан зохицуулалтын талаар товч толилуулна. Гуравдугаар бүлэгт бусад орны цахим мөнгөн гуйвуулгын зохицуулалт, сорил, ба шийдвэрлэлт, Дөрөвдүгээр бүлэгт зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт, Тавдугаар бүлэгт Монгол Улсын цахим мөнгөн гуйвуулгын өнөөгийн байдал, зохицуулалтын хүрээг танилцуулах ба сүүлийн бүлэгт судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж, саналыг дэвшүүлнэ.

## ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД, ТӨРӨЛ, АНГИЛАЛ, ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

### 2.1. Олон улсын эрх зүйн нийтлэг зохицуулалт

ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, цахим аюулгүй байдал, гэрээний нөхцөл, хил дамнасан зохицуулалт зэрэг хууль эрх зүйн олон шинж

чанарыг агуулдаг. Эдгээр хууль эрх зүйн шаардлагыг хангаж дагаж мөрдсөнөөр ББСБ-ууд санхүүгийн системийн аюулгүй байдлаа хангаж, харилцагчдадаа хариуцлагатай, найдвартай үйлчилгээ үзүүлж тэднийг санхүүгийн болон залилан мэхлэх гэмт хэргээс хамгаалж чаддаг.

Иймээс өнөөдөр олон улсад нэгдсэн эрх зүйн зохицуулалт боловсруулан хамтран хэрэгжүүлж байна.



Мөнгө угаах (anti-money laundering (AML)) болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (counter-terrorist financing (CTF)) арга хэмжээний дэлхийн стандартыг тогтоодог Засгийн газар хоорондын байгууллага болох

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (The Financial Action Task Force (FATF) (ФАТФ)) юм.

ФАТФ-аас гаргасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмж нь ББСБ санхүүгийн системийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд зориулагдсан бөгөөд тэр дундаа харилцагчаа сайтар нягтлан шалгах, таньж мэдэх, бүртгэл хөтлөх, тайлагнах шаардлагын талаар зааварчилгаа өгдөг. Энэ нь ББСБ-ыг залилан мэхлэх үйлдлээс болон мөнгө угаахаас урьдчилан сэргийлж хамгаалахад тусалдаг.



Цахим мөнгөн гуйвуулгын стандартыг тогтоосон бас нэг байгууллага бол Олон улсын стандартчиллын байгууллага (the International Organization for Standardization (ISO)) юм. Тус байгууллагаас ISO 20022

стандартуудыг боловсруулсан. Энэ стандарт нь санхүүгийн байгууллагуудын хооронд цахим мессеж солилцох нийтлэг тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд мөнгөн гуйвуулга, цахим төлбөрийг найдвартай гүйцэтгэхэд тусалдаг.



Олон улс орон, бүс нутагт хэрэгжиж байгаа Европын холбооны төлбөрийн үйлчилгээний 2 (Payment Services Directive (PSD2)) стандарт юм. PSD2-ын гол зорилго нь (i) Европын төлбөрийн илүү нэгдсэн, үр ашигтай зах зээлд хувь нэмэр оруулах; (ii) шинэ тоглогчдыг оролцуулах замаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн өрсөлдөөний талбарыг цаашид жигдрүүлэх; (iii) төлбөр тооцоог илүү найдвартай хийх; (iv) Европын хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн эрх ашгийн хамгаалалтыг сайжруулах.

Энэ нь ББСБ-аас харилцагчийг таньж мэдэх баталгаажуулалтын арга хэмжээг дагаж мөрдөх, гүйлгээний мэдээллийг эрх бүхий гуравдагч этгээдтэй хуваалцахыг шаарддаг.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Худалдааны Хуулийн Комисс (United Nations Commission on International Trade Law (UNCITRAL))

2005 онд ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой заалтуудыг багтаасан Цахим шилжүүлгийн бүртгэлийн тухай загвар хуулийг боловсруулжээ.

Загвар хууль ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлсэн. Тус хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах, хил дамнасан худалдааг хөнгөвчлөх, цахим шилжүүлэг, тэр дундаа тоон гарын үсгийг мөнгөн гуйвуулгад ашиглах тогтолцоог бүрдүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах зорилготой юм.

Ийнхүү цахим шилжүүлгийн бүртгэлийг ашиглах, зохицуулах талаар зааварчилгаа өгснөөр цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өсөлтийг дэмжих, санхүүгийн хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Загвар хуульд ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй холбоотой тусгасан үндсэн ойлголтуудаас дурдвал:

**Цахим шилжүүлгийн бүртгэл** – Энэ нь цахим мөнгөн гуйвуулга гэх мэт санхүүгийн хөрөнгийг өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг агуулсан цахим бүртгэл юм. Хуулиар цахим бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хамгаалж, шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах боломж олгосон.

**Дамжуулж болох бүртгэлийн системүүд** – Цахим мөнгөн гуйвуулгын эрх үүсгэх, хадгалах, дамжуулах боломжийг олгодог системүүд юм. Загвар хуулиар дамжуулж болох бүртгэлийн системүүдийг бий болгох, ажиллуулах талаар зааварчилгаа өгч, тэдгээрийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдалд тавигдах шаардлагыг тодорхойлсон.

**Зуучлагч** – Энэ нь илгээгч болон хүлээн авагчийн хооронд цахим мөнгөн гуйвуулгын шилжүүлгийг гүйцэтгэгч ББСБ юм. Загвар хуульд зуучлагчдыг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, зохицуулах асуудлыг тусгасан бөгөөд тэдний үйл ажиллагаанд тавигдах шаардлага, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

**Зөвшөөрөл ба хэрэгжилт** – Загвар хуульд тоон гарын үсгээр мөнгөн гуйвуулах болон холбогдох цахим бүртгэл, түүний дотор цахим шилжүүлгийн бүртгэл, дамжуулж болох бүртгэлийн системүүдийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, мөрдүүлэх талаар тусгасан.

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай** – мөн уг хуульд төлбөр, хураамжийг ил болгох шаардлага, маргаан шийдвэрлэх механизм зэрэг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой заалтуудыг тусгажээ.

## Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд оролцогчид, төрөл, ангилал

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоо гүйцэтгэх ажиллагааг; гэж заасан.

ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулга нь төрөл бүрийн дижитал платформ ашиглан хувь хүн, аж ахуйн нэгж аль нь байхаас үл хамааран мөнгө гуйвуулах хэрэгцээг хангахаар улс дотроо болон өөр бусад улс орон руу илгээх, хүлээн авагчид найдвартай аюулгүй хүлээлгэн өгөх үйлчилгээ гэж ойлгож болно.

ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний оролцогч, төрөл, ангиллыг авч үзье:

### Оролцогчид:

- ◆ **Илгээгч** – цахим мөнгөн гуйвуулгын гүйлгээг эхлүүлсэн хувь хүн эсвэл аж ахуйн нэгж.
- ◆ **Хүлээн авагч** – шилжүүлсэн мөнгийг хүлээн авч буй хувь хүн, аж ахуйн нэгж.
- ◆ **ББСБ** – цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх эрхтэй ББСБ.

### Төрөл:

- ◆ **Хүнээс хүнд (Person-to-person (P2P))** – хувь хүмүүс хооронд;
- ◆ **Хүнээс бизнес рүү (Person-to-business (P2B))** – хувь хүнээс аж ахуйн нэгж рүү;
- ◆ **Бизнесээс хүн рүү (B2P)** – аж ахуйн нэгжээс хувь хүнд;
- ◆ **Бизнесээс бизнес рүү (Business-to-business (B2B))** – нэг аж ахуйн нэгжээс нөгөөд аж ахуйн нэгжид.

### Ангилал:

- ◆ **Дотоодын** – улс дотор;
- ◆ **Хил дамнасан** – гадаад улс орнууд руу;
- ◆ **Шуурхай** – шууд мөнгөө шилжүүлэх;
- ◆ **Хойшлогдсон** – мөнгө шилжүүлэхэд саатал орох;

- ◆ **Банкаар удирдуулсан** – уламжлалт банкуудын санал болгодог цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
- ◆ **Финтекээр удирдуулсан** – финтек компаниудын санал болгож буй цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
- ◆ **Мобайл мөнгө удирддаг** – гар утасны мөнгөний платформоор дамжуулан санал болгож буй цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
- ◆ **Урьдчилсан төлбөрт картаар удирдуулсан** – урьдчилсан төлбөрт картын дансаар дамжуулах цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ.

## Цахим мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл

ББСБ цахим мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой үүсэж болзошгүй нийтлэг эрсдэлийг тодорхойлбол дараах байдалтай байна. Үүнд:

- ◆ **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэх мэт хууль бус үйл ажиллагаанд ашиглаж болзошгүй юм. Энэ нь ББСБ болон зохицуулах байгууллагуудад эрсдэл үүсгэх боломжтой.
- ◆ **Хэрэглэгчийн эрх ашгийг хохироох:** ББСБ-ууд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлснээр хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож болно. Иймээс үйлчилгээний мэдээллийг ил тод, шударга байлгахын зэрэгцээ шимтгэл, валютын ханшийг тодорхой зааж өгөх ёстой. Энэ нь хэрэглэгчдээс ирэх аливаа гомдол, асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болно.
- ◆ **Кибер аюулгүй байдал:** Мөнгө гуйвуулгын үйлчилгээнд дижитал технологийг ашиглах нь хакердуулах, мэдээлэл алдагдах боломжтой. Иймд ББСБ нь өөрийн ашиглаж буй систем, өгөгдөл, мөн харилцагчдынхаа хувийн болон санхүүгийн мэдээллийг хамгаалахад зохих арга хэмжээ авах хэрэгтэй.
- ◆ **Эрх зүйн асуудал:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь хил дамнасан гүйлгээ хамардаг тул тухайн улс орны зохицуулагч байгууллагуудын харьяаллын асуудал үүсгэх боломжтой. Энэ байдлаас болж ББСБ нь илгээгч болон хүлээн авагчийн аль алиных нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

- ◆ **Зөвшөөрөл ба зохицуулалт:** ББСБ–аас үзүүлж буй цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээндээ тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг мөрдөх нь ББСБ–дад нэмэлт зардал, захиргааны дарамт үүсгэж болох ч үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой.
- ◆ **Уламжлалт мөнгөн гуйвуулгын сувгийг тасалдуулах:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өсөлт нь уламжлалт мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Учир нь уламжлалт бол бэлэн мөнгөнд суурилсан шилжүүлгийг оператор үйлддэг тул салбарын зохицуулалтаас гадна санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд нөлөөлж болно гэж үзэж байна.

*Үргэлжлэлийг дараагийн дугаараас*





САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

## Цуврал №27

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

### ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Байгууллага богино хугацааны хөрвөх чадварын хэрэгцээгээ хангах зорилгоор авлагаа гуравдагч этгээдэд худалдах, уг этгээд нь авлагыг цуглуулж, үүсэх эрсдэлийг бүрэн хариуцах санхүүгийн үйлчилгээний хэлбэр юм.




### Факторингийн үйлчилгээний төрлүүд

1	Хариуцах факторинг		Худалдагч байгууллагад бий болох эрсдэлийг өөрөө хариуцана.
2	Үл хариуцах Факторинг		Факторингийн байгууллага худалдагчийн зээлийн эрсдэлийг хариуцна.
3	Хөнгөлөлттэй факторинг		Авлагыг цуглуулах үүргийг худалдагч хариуцдаг тул шимтгэлийн хэмжээ бага.
4	Банкны оролцоотой факторинг		Худалдагчийн бүх авлагыг бүрэн санхүүжүүлнэ.
5	Дотоодын болон хил дамнансан факторинг		Дотоодод болон олон улсад факторингийн үйл ажиллагаа явуулдаг.
6	Олон талт факторинг		Дээрх үйлчилгээнүүдээс 2 болон түүнээс дээш төрлийн үйлчилгээ үзүүлдэг.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР





**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**


## Цуврал №27

*Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд*

### Факторингийн үйл ажиллагааны явц

Худалдагч тал нь бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчид хүргүүлэх болон төлбөр хийх хугацааг тохирно.

Худалдагч нь худалдан авагчаас бараа, бүтээгдэхүүний үнийг нэхэмжлэх эрхийг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид (банк болон зээлийн байгууллага)-д шилжүүлнэ.




Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь үлдэгдэл төлбөрийг худалдагчид шилжүүлэх ба өөрийн үйлчилгээний шимтгэлийг суутган авна.

Худалдан авагчийн зүгээс бараа, бүтээгдэхүүний үнийг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь худалдсан бараа бүтээгдэхүүний үнийн тодорхой хэсгийг ( жишээ нь: 70 хүртэл хувь) худалдагчид шилжүүлнэ.


### ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

#### Давуу тал



- 1 Байгууллагын зээлийн эрсдэлийг бууруулдаг.
- 2 Авлагыг урьдчилан авснаар бизнесийн байгууллагын хөрөнгийн эргэлтийг хурдасгадаг.
- 3 Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг дэмждэг.

#### Дутагдалтай тал



- 1 Факторингийн үйлчилгээ авснаар шимтгэл төлнө.
- 2 Факторингийн үйлчилгээ авснаар худалдагч болон худалдан авагчийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг.
- 3 Ашиг бууруулдаг

### ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ИХ ХЯТАДЫН ДНБ ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ 5.5 ХУВИАР ӨСЖЭЭ



БЭЭЖИН. /Xinhua/. Хятадын эдийн засгийн өсөлт 2023 оны эхний зургаан сард 5.5 хувь байсан гэж тус улсын үндэсний статистикийн газар мэдээлэв. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Хятадын ДНБ-ий хэмжээ 59.3 их наяд юаньд хүрчээ.

Тус байгууллагын хэвлэлийн мэдээнд дурдсанаар, энэ хугацаанд Хятадын хөдөө аж ахуйн салбар 3.7 хувиар, 3.04 их наяд юань, аж үйлдвэр 4.3 хувиар, 23.06 их наяд юань, үйлчилгээний салбар 6.4 хувиар тус тус өсөж, 33.19 их наяд юаньд хүрчээ. 2023 оны хоёрдугаар улиралд Хятадын ДНБ-ий өсөлтийн хурдац 6.3 хувьтай байсан нь эхний улирлынхаас (4.5 хувь) 1.8 пунктээр илүү байна.

2022 онд Хятадын ДНБ 3 хувьд хүрч удааширсан юм. Зургаадугаар сард “Goldman Sachs” банкны шинжээчид Хятадын эдийн засгийн 2023, 2024 оны өсөлтийн талаарх таамаглалаа 6 хувиас 5.4 хувь, 4.6 хувиас 4.5 хувь болгон тус тус бууруулсан байна. Хятад улс 2034 он гэхэд ДНБ-ий хэмжээгээр АНУ-ыг гүйцэж түрүүлнэ гэж “Focus Economics” байгууллагын шинжээчид таамаглажээ.

*Эх сурвалж: www.montsame.mn*

### ХЯТАД УЛС ЯПОНЫ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫГ ХЯЗГААРЛАЖЭЭ

БЭЭЖИН. /Xinhua/. Японы “Фүкүшима-1” атомын цахилгаан станцын /АЦС/ цацраг идэвхт бодисоос цэвэрлэсэн усыг далайд асгах шийдвэр гарсантай холбогдуулан тус улсын 10 мужаас бүтээгдэхүүн импортлохыг хориглож байгаагаа БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар мэдэгджээ.

“Цацраг идэвхт бодисоор бохирдсон япон хүнсийг Хятад руу экспортлохоос сэргийлж, Хятадын хэрэглэгчдийн импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үүднээс Хятадын гаалийн байгууллага Фүкүшима зэрэг 10 мужаас хүнсний бүтээгдэхүүн импортлохыг хориглож байна” гэж мэдэгдэлд дурдсан байна.

Японы Цөмийн эрчим хүчний зохицуулах газар уг станцын усыг далайд асгах төлөвлөгөөг 2023.07.07-ны өдөр баталсан юм.

Олон улсын атомын эрчим хүчний агентлаг /ОУАЭХА/ АЦС-ын усыг далайд асгах Японы төлөвлөгөөний талаарх тайлангаа



2023.07.04-ны өдөр танилцуулж, уг төлөвлөгөө нь олон улсын стандартад нийцэж байгааг онцолсон байна. Станцын усыг далайд асгаснаар бүс нутгийн оршин суугчид болон экологийн тогтолцоонд маш бага нөлөөлнө гэж ОУАЭХА үзэж байгааг тус байгууллагын тэргүүн Рафаэль Гросси мөн Токиод болсон хэвлэлийн бага хурлын үеэр онцлон тэмдэглэжээ.

Одоогийн байдлаар 2011 оны гуравдугаар сард цунамиин улмаас осол гарах үед реакторуудыг хөргөхөд ашиглаж байсан 1.25 сая гаруй тонн ус станцын нөөцлүүр савуудад хуримтлагдсан байна. Энэ усыг 30 жилийн хугацаанд үе шаттайгаар далайд асгахаар төлөвлөжээ. ОУАЭХА усыг асгах үйл явцад байнгын хяналт тавина. Хэдийгээр усыг цэвэршүүлсэн ч цацраг идэвхт тритий агуулагдсан хэвээр байгаа аж. Японы Засгийн газар усыг далайд асгах үед энэ бодисын агууламж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ундны усны тогтоосон стандартад нийцсэн байна гэж мэдэгдсэн юм.

*Эх сурвалж: www.montsame.mn*

## НҮБ-ЫН АЮУЛГҮЙН ЗӨВЛӨЛ АНХ УДАА ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ АСУУДЛААР ХУРАЛДАНА

НҮБ /un.org/. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2023.07.18-ны өдөр түүхэндээ анх удаа хиймэл оюун ухааны асуудлаар хуралдав.



Энэ тухай урьдчилан байдлаар Их Британи улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгч Барбара Вүүдворд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг Их Британи даргалж эхэлсэнтэй холбогдуулан 2023.07.02-ны өдөр зохион байгуулсан хэвлэлийн бага хурлын үеэр мэдэгджээ.

Тэрээр уг асуудлыг Аюулгүйн Зөвлөлөөр хэлэлцэх нь хиймэл оюун ухаанаас үүдэлтэй асар их боломж, эрсдэлийг зохицуулах олон талын чиг хандлагыг дэмжих боломжийг олгоно гэж онцолсон байна.

Энэхүү хуралдааныг Их Британийн Гадаад хэргийн сайд Жеймс Клеверли даргалсан. Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гутерриш, хиймэл оюун ухааны салбарын мэргэжилтнүүд үг хэлэв.


Эх сурвалж: [www.montsame.mn](http://www.montsame.mn)

## ИЛОН МАСК ТЭРБУМТНУУДЫН ЧАНСААГ ТЭРГҮҮЛЖЭЭ

### Musk's Net Worth Grew the Most in First Half of 2023

World's richest person added \$96.6 billion in past six months

■ YTD change in net worth



Source: Bloomberg Billionaires Index

НЬҮ-ЙОПК. /Bloomberg/. Илон Маск 2023 оны эхний зургаан сарын дотор хамгийн их орлого олсон хүмүүсийн жагсаалтыг тэргүүлээ гэж "Bloomberg" агентлаг даваа гарагт мэдээлжээ.

"Tesla", "SpaceX" компанийг үүсгэн байгуулагч, "Twitter"-ийн эзэмшигч И.Маск сүүлийн зургаан сарын хугацаанд 96.6 тэрбум ам.долларын орлого олжээ.

Жагсаалтын хоёрдугаарт "Meta" компанийн гүйцэтгэх захирал Марк Цукерберг 58.9 тэрбум ам.долларын орлогоороо бичигджээ. Түүний дараа "Amazon" корпорацийг үүсгэн байгуулагч Жефф Безос, "Oracle" корпорацийг үүсгэн байгуулагчдын нэг Ларри Эллисон, "LVMH" группийн ерөнхийлөгч Бернард Арно нар орж байна.

Дэлхийн хамгийн чинээлэг 500 хүн 2023 оны эхний хагаст нийт 852 тэрбум ам.долларын орлого олжээ.

Тэрбумтнуудын хувьд энэ оны эхний хагас жил "Covid" цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн уналтын дараа сэргэсэнээс хойших хамгийн сайн хагас жил байлаа гэж "Bloomberg" онцолсон байна.


Эх сурвалж: [www.montsame.mn](http://www.montsame.mn)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 7 дугаар сарын 25-ны өдөр

S&P 500 /^GSPC/


**4,554.64** +18.30 (+0.40%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Nikkei 225 /^N225/


**32,612.57** -88.37 (-0.27%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

FTSE 100 /^FTSE/


**7,678.59** +14.86 (+0.19%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

NASDAQ Composite (^IXIC)

**14,058.87** +26.06 (+0.19%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн Зохицуулах Хороо



@FRC\_of\_Mongolia